

ДеФакто **ТОЙМ**

➤ АРИЛЖААНЫ БАНКУУДЫН
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

➤ ХӨШИГИЙН ХӨНДИЙН
ОНГОЦНЫ БУУДЛЫН
"ЗОХИОМОЛ" НЭЭЛТ

➤ ХАВРЫН ЧУУЛГАНЫ
ХААЛТ БА ЭЭЛЖИТ БУС
ЧУУЛГАНЫ НЭЭЛТ

VIII НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

ПОСТ КОММУНИЗМЫН ЭМЗЭГ ЦЭГ

II НҮҮРТ



БОЛОВСРОЛ

Б.Насанбаяр
Ph.D /Боловсрол судлал/

БОЛОВСРОЛ БА АЖИЛ ЭРХЛЭЛТ

V НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2019.07.10, №1 (105)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.defacto.mn

ПОСТ КОММУНИЗМЫН ЭМЗЭГ ЦЭГ



Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

ПОСТ КОММУНИЗМЫН ЭМЗЭГ ЦЭГ

Ардчилсан шилжилтээс хойш авлигыг тойрсон хэрэг явдлууд манай нийгэм, улс төрийн орчныг тодорхойлох боллоо. Хээл хахуулиас эхлээд эрх мэдэл, албан тушаалын наймаа зэрэг нийгэмд харш үзэгдлийг ерөнхийд нь авлига гэсэн малгайн дор ойлгож, ярихаас гадна тэмцэж, шийдэл хайсаар өдийг хүрэв. Авлига нь олон янзын хэлбэр, дүрстэй бөгөөд тус бүртээ нь тэмцэх өөр өөрийн арга, шийдлийг ч шаарддаг. Манайх шиг эдийн засаг буурай орнуудад хөгжлийн хамгийн том сорилт болоод буй авлигыг үндсэндээ хоёр төрлийн үзэгдэлд Фрэнсис Фукуяама хуваан тайлбарлажээ.

1 Эхнийх нь төрийн янз бүрийн лиценз, зохицуулалтаас үүсдэг Рент (rent-seeking) гэх үзэгдэл. Рент нь эдийн засагт бодит зардлаас давсан хэт өндөр ашиг олохыг хэлдэг бөгөөд энэ бол байгалийн баялагтай орнуудын нийтлэг зовлон. Энгийн үгээр хэлвэл зовлон багатайгаар өндөр ашиг олохыг рент гэж болно. Төрийн эрх мэдлээ ашиглаж зовлон багатайгаар бизнес хийх сонирхолтой бүлгийг “rent-seekers” гэнэ.

2 Удаах үзэгдлийг клиентелизм (clientelism) гэдэг. Клиентелизм гэдэг нь клиент буюу үйлчлүүлэгч гэдэг үгнээс үүсэлтэй бөгөөд бизнесийн хамтрагч хэлбэрээр улс төрийн эрх мэдэлд гарах, дараа нь эрх мэдлээ ашиглаж үйлчлүүлэгчиддээ ашигтай боломж олгохыг хэлдэг. Монголд ил тод болж буй 60 тэрбумын гэх, ЖДҮ зээлийг УИХ-ын гишүүд хувааж авсан зэрэг хэргүүд клиентелизм манайд өргөн дэлгэр цэцэглэн хөгжиж ирсний бодит баталгаа юм. Энэ үзэгдэлд бас Үнэ тогтворжуулах хөтөлбөр, Хөгжлийн банкны зээл, концессийн гэрээнүүд зэрэг урт жагсаалт хамрагдана. Товчхондоо манай өнөөгийн улс төрийн орчныг клиентелист улс төр гэж тодорхойлж болно.

ЗАЛУУ АРДЧИЛЛЫН ЗОВЛОН

Клиентелизм мэдээж шинэ зүйл биш. 19-р зууны АНУ-д ч сонгуулиар ялсан нам нь нийтийн албыг худалдан хуваадаг клиентелизмийн зуршил тогтоод байлаа. Нэгэнт амласан албан тушаалдаа томилоогүй гэж шинээр сонгогдсон ерөнхийлөгч Жеймс Гарфийлдийн амийг хүртэл хороосон байдаг. Энэ хэрэг явдал мерит зарчимд суурилсан Төрийн албаны тухай хууль батлахад хүргэж улс төрийн наймаанаас нийтийн албаа хамгаалах болжээ. Мөн Австрид 20-р зуунд орон нутгийн цэцэрлэг, сургуулийн удирдлагуудаас эхлээд төрийн албан тушаалыг хоёр

нам нь хувааж авдаг “Пропорц” гэх систем дэлгэрсэн байлаа. Эдгээр түүхэн жишээ нь клиентелизм өнөөгийн ардчилсан хөгжингүй орнуудад ч тодорхой цаг үед оршиж байсныг харуулж байна.

Манай орны хувьд дээрх хоёр бүлгийн үзэгдлүүд сүүлийн 30 жилийн нийтийн засаглалын сул дорой байдлын суурь шалтгаан, бодит гацаа нь юм. Улс төрийн нам, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь нийтийн санаа бодлыг хэлбэршүүлж, хүсэл зоригийг илүү зохион байгуулалттайгаар илэрхийлэх үүрэгтэй сувгууд юм. Гэвч өнөөдөр манай хэвлэл мэдээллийн ►►

► хэрэгслүүдийн 70 гаруй хувь нь улс төрийн өндөр албан тушаалтнуудын өмч болжээ. Харин улс төрийн намууд нь нийтийн санаа бодлыг төлөвшүүлэхэд оролцохын оронд клиентелизмийг хэрэгжүүлдэг бүтэц

АРДЧИЛЛЫН СУУРЬ БАГАНА

Францын улс төр судлаач Алекси дө Токвиль Америк дахь ардчилал бүтээлдээ иргэний нийгмийг хамгийн энгийнээр “Ардчиллыг байгуулахад иргэний нийгэм зайлшгүй урьдач нөхцөл болох бөгөөд ямарваа нэг асуудал тулгарахад хүмүүс сайн дураараа нэгдэж мэдлэг, мэдээлэл, цаг заваа хуваалцан шийдэл олдог нийгмийг хэлнэ” гэжээ. Харин орчин үеийн ойлголтоор бол иргэний нийгэм нь үндсэн гурван эрхийг хэрэгжүүлэгч төрөөс хараат бус, чөлөөт талбар юм. Энэ гурав нь эвлэлдэн нэгдэх, жагсаж цуглах, үзэл бодлоо илэрхийлэх явдал юм.

Бид шинэ нийгэмд шилжихдээ иргэний нийгмийн суурь эрхийг Үндсэн хуулиараа баталгаажуулсан. Харин иргэний нийгмийн гол төлөөлөл болох төрийн бус байгууллагуудын тусгайлсан хуулийг 1997 онд баталсан. Энэ цаг үеэс хойш өнөөдөр 20 мянга гаруй

ЭМЗЭГ ЦЭГ

Ардчиллаас өмнө иргэний нийгмийн хөрс суурь бүрдээгүй манайхтай адил шилжилт хийсэн зарим пост-коммунист орнуудад нийгэм, улс төрийн ижил төсөөтэй үйл явдлууд өрнөж байна. 1990 оноос өмнө эдгээр орнуудын түүхийн тодорхой хэсгийг тоталитар дэглэм тодорхойлж байв. Тоталитар дэглэм бол юуны өмнө иргэний нийгмийг устгадаг. Ийм ч учраас тоталитар дэглэмээс ардчилалд шилжиж буй орнуудад иргэний нийгмийн суурь хөрс байхгүй байлаа.

Улс төр судлаач Михаль Клима “Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу” бүтээлдээ харуулсан Чех орны сүүлийн 25 жилийн клиентелизмийн тогтолцоо, улс төрийн намуудын хямралын дүр зураг нь Монголтой тун төсөөтэй харагдаж байна. Чехийн нийгэм, улс төрийн орчинд буй иргэний нийгмийн хоосон орон зай нь энэ улсын ардчилсан шилжилтийн хамгийн эмзэг цэг нь болоод байна гэж тэр дүгнэжээ.

Гэвч энэ нөхцөл байдалтай зэрэгцээд дөнгөж бүрэлдэн тогтож эхэлсэн иргэний нийгмийн багавтар орон зайг дээрээс нь хязгаарлах оролдлого ардчилалд шилжсэн орнуудаас хамгийн тогтвортойд тооцогдож

болж хувирав. Харин ийм нөхцөл байдалд нийтийн засаглалыг эрүүл байлгах чөлөөт талбар бол иргэний нийгэм юм.

төрийн бус байгууллага бий болсон нь иргэд эвсэлдэн нэгдэх эрхээ чөлөөтэй эдлэж байгааг харуулна. Хэдий иргэний нийгмийн үндсэн байгууллагуудын тоо ихэссэн ч чанар, төлөвшлийн асуудал нь эргэлзээтэй хэвээр.

Өнөөдрөөс 15 жилийн өмнө дэлхийн иргэний нийгмийн эвсэл (*CIVICUS*) монгол дахь иргэний нийгмийн хөгжил, төлөвшилд анх удаа үнэлэлт, дүгнэлт өгч байв. Тус тайланд монголын иргэний нийгэм төр засагтаа хариуцлага хүлээлгэх, төрийн бодлогод нөлөөлөх чадамж харьцангуй доогуур, сул гэж дүгнэж байсан. Бодит баримт, нотолгоотой авлигын хэргүүд илэрсэн ч ямар нэг хариуцлага хүлээлгэх түвшинд хүрээгүй байна. Нийтийн засаглалд үзүүлэх иргэний нийгмийн нөлөө одоо ч хангалттай хэмжээнд төлөвшөөгүй байгаа.

байсан Зүүн Европд хүчтэй өрнөж байна.


Евро бүсийн дүрвэгсдийн хямрал, эрх баригчдынхаа авлига хээл хахуулийн хэргүүдэд туйлдсан Зүүн Европын орнуудад баруун, зүүн төвийн радикал намууд Засгийн эрхэнд гарах боллоо. Улмаар хараат бус шүүхийн эрх мэдэл, иргэний нийгмийн орон зайг булаах үйлдлүүд гарсаар байна.

Ардчилсан шилжилтийн 30 жилийг авлига, түүнд хамаарах үзэгдлүүд тодорхойлсон бол дараагийн гурван арваньг нийгэм, улс төрөө хэрхэн бүрдүүлэх нь иргэний нийгмээс ихээхэн шалтгаалах юм аа. Нийтийн засаглалын хямралаас гарч, засч тохинуулах буюу клиентелист тогтолцооноос салах түлхүүр нь хүчтэй иргэний нийгэм юм.

Эцэст нь Михаль Климагийн хэлснээр “Хэрэв иргэний нийгэм нь өөрийн орлуулшгүй үүргээ гүйцэтгэж чадахгүй юм бол тухайн оронд зөвхөн нэр төдий клиентелист ардчилал, эсвэл бүр авторитар дэглэм л бүрдэх болно”.

2019.07.10

ХӨДӨЛГҮҮРИЙН МӨНХИЙН ҮС



**TOTAL QUARTZ 9000
5W-40**



**ДОКТОР АВТО СҮЛЖЭЭ
ДЭЛГҮҮРИЙН БҮХ САЛБАРААР
ХУДАЛДААЛАГДАЖ ЭХЭЛЛЭЭ.**

Холбоо барих утас: 9411-7143, 9906-6402



www.minesup.mn



@TOTALMongolia



fb.com/TOTALMongolia



@TOTALMongolia

Албан Ёсны Дистрибьютор:

UP
MINES
www.minesup.mn



НИЙТЛЭЛ

Б.НАСАНБАЯР
Ph.D /Боловсрол судлал/


БОЛОВСРОЛ БА АЖИЛ ЭРХЛЭЛТ

Монгол улсад нийт ажиллагсдын тоо 2012 онд 1.05 сая байсан бол 2017 онд 1.18 сая, 2022 онд 1.26 саяд хүрэхээр таамаглал гарчээ. 2022 он хүртэл барилгын салбарын ажил эрхлэлт өсөх хандлагатай, жилийн дундаж өсөлт нь харьцангуй тогтмол 6%-тай байна. Харин үйлчилгээний бусад салбарын ажил эрхлэлт 2022 он хүртэл дунджаар 3.1%-аар буурна гэж 2014 онд Хөдөлмөрийн Судалгааны Институт таамаглажээ. Тус байгууллагаас хөдөлмөрийн зах зээлд гарах голлох өөрчлөлтүүдийг таамагласан хэдий ч хэрэгцээт хүний нөөцийн ур чадварыг тодорхойлоогүй байна.

СУРАЛЦАХ ЧИГЛЭЛ, АЖИЛ ЭРХЛЭЛТ

Монгол улсад дээд боловсрол эзэмшиж буй иргэдийн тоог нийт хүн амд харьцуулахад ихээхэн өндөр үзүүлэлттэй.


Их, дээд сургуульд нийт суралцагчдын мэргэшиж байгаа чиглэлд 2008-2015 онд



Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаагаар хамгийн урт хугацаа зарцуулж ажилтай болж буй мэргэжлийн бүлэгт

БҮЛЭГ	ХУВЬ
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ	48.4
НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХАМГААЛАЛ	45.7
ХҮМҮҮНЛЭГИЙН УХААН	42.9

Эдгээр салбарт ажлын байр харьцангуй эрэлт ихтэй байгаа нь энэ өсөлтийн нэг хүчин зүйл болж байна.



Их, дээд сургууль төгсөгчдийн 58.5% нь ажил үүрэг болон мэргэжлийн нийцтэй түвшнээр “тохирдог”, “маш сайн тохирдог” гэсэн үнэлгээ авч төгсөгчдийн талаас илүү хувь нь эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу ажиллаж байгаа нь судалгаагаар тогтоогджээ.

Тухайн мэргэжлийн чиглэлийн нийт төгсөгчдийн 70-аас дээш хувь нь мэргэжлийн дагуу ажиллаж байгаа өндөр үзүүлэлттэй мэргэжлийн чиглэлүүдээс дурдвал

ЧИГЛЭЛ	ХУВЬ
УРЛАГ	75.7
МЭДЭЭЛЭЛ, СЭТГҮҮЛ ЗҮЙ	75.6
КОМПЬЮТЕР, АНАГААХ УХААН	74.4
БИОЛОГИ	72.2
БАРИЛГА АРХИТЕКТУР	72.1

Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэг нь эзэмшсэн мэргэжлээс өөр чиглэлээр ажиллаж буй дундаж нь 20.5% байгаа юм.

Дээд боловсролын салбарын доорх мэргэжилтнүүд мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлттэй байна.

ЧИГЛЭЛ	ХУВЬ
НИЙГМИЙН ХАЛАМЖ- ХАНГАМЖ	42.9
ТЭЭВЭР	36.1
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ	32.3
ХҮМҮҮНЛЭГИЙН УХААН	32.1
БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ	31.6

Их дээд сургуулийн өмчийн хэлбэр үл хамааран төгсөгчдийн нийтлэг ур чадварын хомсдол нь ёс зүй, харьцаа хандлага, багаар ажиллах чадвар, мэдээллийн технологи ашиглах, суралцах чадвар, гадаад хэлний мэдлэг байна. Ажил олгогчид ажилтандаа тавьж буй шалгуурын талаарх судалгааны эхний тавд

- ♦ Бичгийн харилцааны ур чадвар
- ♦ Үнэнч шударга, зарчимч байдал
- ♦ Багаар ажиллах ур чадвар
- ♦ Харилцааны ур чадвар
- ♦ Ёс зүй зэрэг ур чадварууд байгаа бол голч дүн 13-рт байна.

Харин Global Human Capital Report (WEF, 2017)-д өнөөгийн хурдтай өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд хүүхэд, залуус зохицон амьдрахад:

- ♦ Санаачилгатай байх
- ♦ Амаар болон бичгээр өөрийгөө зөв илэрхийлдэг байх
- ♦ Сониуч зантай байх
- ♦ Төсөөлөх чадвар эзэмших боломж олгох талаар онцолжээ.

АЖИЛ ЭРХЛЭЛТ БА УР ЧАДВАР

Технологийн дэвшил, хүмүүс хоорондын харилцаа, улс орнуудын хөгжлийн түүх, боломж зэрэгт анализ хийж, ирээдүйг таамагладаг ирээдүй судлалын олон улсын нийгэмлэг үүсчээ. Энэ нийгэмлэгийн үндэслэгч Жон Нэйсбитийн аргачлалд үндэслэж, 2050 он хүртэл дэлхийд юу болох талаар судалсан багийн тайлангийн илтгэлд “Хөгжил Европ, Хойд Америкаас илүү өмнө зүг рүүгээ төвлөрч байна. 2050 он гэхэд дэлхийн хамгийн том эдийн засаг Хятад болно” гэжээ. Бидний хөрш зэргэлдээ оронд дэлхийн баялаг төвлөрөх нөхцөл аль хэдийн бий болжээ. Энэ боломж, нөхцлийг Монгол улс ашиглахын тулд ажилчин бэлтгэхээс илүүтэй шинжлэх ухаан, инженер, харилцаа холбооны технологи, судалгаа боловсруулалтын өндөр ур чадвартай дээд боловсролтой иргэдийг бэлтгэхэд онцгой анхаарах учиртай.

Их сургууль төгсөөд, насаараа нэг албан байгууллагатай амьдралаа холбодог байсан үе аль хэдийн ард хоцорчээ. Их Британид хүн амьдралынхаа туршид 13 удаа, АНУ-д 10.6 удаа ажлаа сольж, дөрвөн мэргэжил эзэмших болсон зэрэг олон өөрчлөлтийг бид хүлээн зөвшөөрөхөөс аргагүйд хүрч байна. Япончууд өмнө нь “Тогтвортой ажил эрхлэлтийн бодлого” ярьж байсан бол өдгөө “урсамтгай ажил” (labor fluidity)-ын тухай онцолж байна.

Энэ цаг үед их дээд сургуулиуд сургалтын орчин, нөхцлийн шинэчлэлд мэдээллийн технологийг хэрхэн ашиглаж суралцагчдад олон талын боломж олгох вэ? гэдэгт ухаанаа уралдуулахаас өөр сонголтгүй. Саяхан болтол хүмүүс ажлаа хөнгөвчлөхийн тулд робот бүтээж юуг роботоор хийлгэж болох вэ? гэдэг байсан

бол өнөөдөр роботоор юуг хийлгэж болохгүй вэ? гэсэн асуудлыг шийдэх хэрэгтэй болжээ.

Их дээд сургуульд суралцагчдын академик мэдлэг, мэдээлэл төгсөх үед нь аль хэдийн хуучирсан байх ирээдүй хүлээж байна. Иймээс их дээд сургуулиуд жишээ нь: оюутнуудыг түүхийн тухай зүгээр л унших төдий бус, тухайн түүхэн үйл явдалд өөрөө оролцож байгаа мэт дадлага хийж, олон эх сурвалжаас хайлт хийн, дүгнэлт шийдвэр гаргах боломж олгох зэргээр сургалтын үйл явцад өөрчлөлт хийх нь чухал гэдгийг хүлээн зөвшөөрөх учиртай. Дээд боловсролын байгууллагуудын менежмент, соёл, сургалт, үйл ажиллагаа нь хүн болох, зөв дадал, суралцах арга барилд суралцах боломж олгох, сургалтын хөтөлбөрийг сургууль бүр өөрийн онцлог, давуу талд суурилан тасралтгүй хөгжүүлж, мэдээллийн технологийг амжилттай ашиглан, хэрэгжүүлэхээс төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, сургуулийн хувь заяа хамаарна.

Улс төрөөс хэт хараат удирдлага менежменттэй, санхүүжилтийн 90 гаруй хувийг зөвхөн сургалтын төлбөрөөс бүрдүүлдэг жишгээр бид ирээдүйд тэнцэж амьдрахад, дээд боловсролын салбарыг хөгжүүлэхэд, ажил эрхлэлт, хүний нөөцийн хөгжлийн шийдэл гаргахад тун бэрх юм. Ажил олгогчид их дээд сургуулиудын хамтын ажиллагаа бэхжиж, улс төрөөс хараат бус болж, компаниуд бөх, морь байлдаг жишгээрээ сургалт, судалгааны үйл ажиллагаанд хөрөнгө оруулдаг болвол бид нийтээрээ хожно.

2019 оны 7-р сар

ДАРАА ТӨЛБӨРТ

шинэ хэрэглэгчид

БАРЬЦАА ТӨЛБӨР БҮРТГЭЛИЙН ХУРААМЖ

0

ТӨГРӨГ

ЯРИА

Сүлжээндээ хязгааргүй

7.000₮Сүлжээндээ хязгааргүй
Бусад сүлжээнд 250 минут**17.000₮**Сүлжээндээ хязгааргүй
Бусад сүлжээнд 1000 минут**27.000₮**

ДАТА

Хязгааргүй 2GB

12.000₮

Хязгааргүй 10GB

28.000₮

Хязгааргүй 5GB

20.000₮

Хурд, хэрэглээний хязгааргүй

42.000₮

МЕССЕЖ

Сүлжээндээ өдөр бүр 200ш

2.000₮Сүлжээндээ өдөр бүр 200ш
Бусад сүлжээнд сард 500ш**4.500₮**



ДеФакто ТОЙМ

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.07.07-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

АРИЛЖААНЫ БАНКУУДЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

Үйл явдлын товч:



Манай улс ОУВС-тай хэрэгжүүлж буй хөтөлбөрийн дагуу банкны салбарын активын чанарын үнэлгээг хийсэн байдаг. Арилжааны банкны активын чанарын үнэлгээний дүнгээр долоон банк өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан. Нэг банк нь 2018 оны жилийн эцсийн тайлангаар өөрийн хөрөнгийн дутагдлаа нөхөж чадаагүй учраас 4-р сард татан буугдсан. Одоо өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн гэх банкуудын нэмэгдүүлсэн эх үүсвэрийг шалгах ажил явж байгаа.

Өнгөрөгч 3-р сард Монголбанк ОУВС-тай арилжааны банкуудад магадлан шинжилгээг хийе гэж ярьсан. Ингэхдээ ажлын даалгаврыг 4-р сарын сүүлээр бэлэн болгосон. Тэгээд Монгол улсын хуулийн нийцэл нь юу байх вэ гэдэгт Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Засгийн газар, ОУВС-тай хамтран ажилласан. Үүний дагуу 5-р сарын эхээр хийж, одоо энэ чиглэлээр олон улсад мэргэшсэн нэр хүнд бүхий санхүүгийн аудитын үйлчилгээ үзүүлдэг компанийг сонгон шалгаруулж, ажил нь эхлээд 14 хонож байна. Урьдчилсан байдлаар 8-р сарын хоёр дахь долоо хоног гэхэд магадлан шинжилгээний ажлыг зургаан банкинд хийж дуусгана гэж Монголбанкнаас хэлсэн. Мөн чанаргүй активыг бууруулах зорилготой Актив удирдлагын тусгайлсан институт байгуулахаар УИХ-ын зарим гишүүд хуулийн төсөл өргөн бариад байна.

Дүгнэлт тайлбар:

Магадлан итгэмжлэх гэдэг нь шалгаж, дахин баталгаажуулна гэсэн санааг хэлж байгаа. Банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэхэд монголын улс төрчид оролцсон байна уу эсвэл бизнес эрхлэгчид орсон уу? гэх асуултын дагуу цаад мөнгөний эх үүсвэр нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийг зөрчсөн байж болзошгүй байгаа тул дахин шалгаж итгэмжлэнэ.

2011 оноос хойш Монголд мөнгө угаасан байж болзошгүй 4345 хүний хэргийг шалгаснаас 46-г нь мөрдөн байцаасан. Үүнээс зөвхөн 20 хүний хэргийг нь прокурорт шилжүүлж, хоёр хэргийг нь анхан шатны шүүхээс хүнд ял оногдуулсан. Гэвч Дээд шүүх нь доод шатны шүүх хуулийн заалтыг буруу ашигласан гээд мөнгө угаах зүйл ангийг хүчингүй болгож, хоёуланг нь хэрэгсэхгүй болгосон. Мөнгө угаахтай холбоотой хэргүүд энэ мэтчилэн шийдэгддэггүй байдлаас болж Монгол улс Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын байгууллага ФАТФ (FATF) -ын саарал жагсаалтад орох эрсдэлд хүрчихсэн байгаа.

Банкуудын чанаргүй зээлийн хэмжээ эрс нэмэгдсэн учраас активыг удирддаг байгууллагууд гарч ирж байна. 2018 оны 4-р сард системийн нийт зээлийн 7.4 хувь нь чанаргүй буюу 1.06 их наяд төгрөгт хүрсэн байна. Чанаргүй зээл нь банкны үйл ажиллагаа хэвийн үед ч тохиолддог боловч уг зээлийн хэмжээ хэвийн хэмжээнээс өндөр, гадаад хүчин зүйлийн нөлөөлөл их улмаар энэ нь санхүүгийн хямралыг гүнзгийрүүлэх түвшинд хүрээд байгаа үед энэ асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай.

Монгол улсын үл хөдлөх хөрөнгийн зах зээлд хямрал бий болсноор банкуудын барьцаа хөрөнгийн дийлэнхийг эзлэх үл хөдлөх хөрөнгийн үнэ буурсан төдийгүй банкууд барьцаа хөрөнгийг шууд захиран зарцуулах эрхгүй, чанаргүй зээлийг төлүүлэхэд нэлээн хүндрэл үүсэж байгаа. Барьцаа хөрөнгөөр зээлийн үүргийг гүйцэтгүүлэхэд шүүхийн болон шийдвэр гүйцэтгэлийн шатанд 3-5 жилийг зарцуулдаг. Энэ нь банкинд хүндрэл болж, алдагдал бий болгоно. Чанаргүй зээлийг өөрийн хөрөнгөөр хаах, өглөгийг бууруулах, банкны эзэмшлийн бүтцийг өөрчлөх, шинэ компани нь тухайн хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй байхаар зохицуулах шаардлага активын менежментийн компаниудад тулгарна.

ХӨШИГИЙН ХӨНДИЙН ОНГОЦНЫ БУУДЛЫН "ЗОХИОМОЛ" НЭЭЛТ

Үйл явдлын товч:

Удаан хугацаанд хулээлгэж байгаа Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлын барилга байгууламжийн ажил дуусч менежментийг эхлүүлэх ёслол болсон. Энэ нисэх онгоцны буудлын менежментийг Япон улстай хийсэн концессын гэрээгээр Монголын тал 49 хувийг, Японы тал 51 хувийг эзэмшихээр болсон байдаг. Мөн тус нисэх онгоцны буудал хүртэл 32 км авто замыг нээсэн.

Дүгнэлт тайлбар:

Улс төрийн шинж чанартай шоу болчихлоо. Нисэх онгоцны буудлын жинхэнэ нээлт болоогүй, эхний нислэгээ хийсэн цагаас эхлэн нээлт боллоо гэж үзнэ. Монголд болж буй олон үйл явдлыг Потемкины тосгод барих гэж хэлж болох бөгөөд бид гадна талын хэлбэртээ онцгой анхаарч, агуулгаа ойшоохгүй, зарим нь бүр ойлгохгүй, түүнийг нь улс төрийн ашиг хонжоо хайсан этгээдүүд овжин ашиглаж, улам хөөсрүүлэн хөөрөгдөж, “хошгируулж” байна.

Бид 11 жилийн өмнө Японоос 65.6 тэрбум иений зээл аваад 10 жилийн дараагаас төлөх үүрэгтэй байсан. Зээлээ төлөөд эхэлсэн ч нисэх онгоцны буудал ашиглалтад ороогүй. 11 жилийн хугацаанд Ерөнхий сайд 6, салбарын сайд нь 9 удаа өөрчлөгдсөн байгаа юм. Манай эрх баригчдын тогтворгүй байдлаас болоод шинэ дарга нар хувийн эрх ашгийг түрүүнд тавьж ажлын комисст өөрчлөлт орсноор төслийн хэрэгжүүлэлт явахгүй, хэрэгжих ёстой төслүүд зогсчихоод байна.

ХАВРЫН ЧУУЛГАНЫ ХААЛТ БА ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ НЭЭЛТ

Үйл явдлын товч:

Өнгөрсөн Баасан гарагт УИХ-ын хаврын ээлжит чуулган өндөрлөлөө. Энэ хугацаанд бие даасан 14 хууль батлаж 74 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан 10 хуулийг хүчингүй болгожээ. Хаврын ээлжит чуулганыг хаасан даруйд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлэлцүүлгийг үргэлжлүүлэхээр ээлжит бус чуулганыг нээлээ. УИХ-ын дарга Г.Занданшатар ээлжит бус чуулганыг нээж хэлсэн илтгэлдээ “ЦЭГЦЛЭХ ЦАГ, ЦЭГЦРЭХ СОНГОЛТ ТА БИДЭНД НОГДООД БАЙНА” гэв.




Дүгнэлт тайлбар:

Нэгдсэн чуулганы ирц нь 60 хувьд хүрдэг болсон байна лээ. Мөн үг хэлэх, санал өгөхдөө хурууны хээгээ ашиглаж эхэлсэн. Хүний өмнөөс кноп дардаг байснаа больсон. 76 сахилгагүй хүүхэдтэй анги шиг л харагдаад байгаа байхгүй юу. Бие биенээ ангийн хүүхдүүд гэдэг юм байна лээ.

Мөн нийтийн сонсгол хийсэн. Өөр нэг онцлог нь АТГ-ын дарга, дэд дарга, Улсын Ерөнхий прокурор, Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн томилгоог нээлттэй хийсэн. Үүнийг би авуштай алхам гэж харж байна. Эцэст нь хүний эрхийн тухай илтгэлийг их хурал дээр хэлэлцсэн. Сүүлийн 10-аад жил ингээгүй байсан.

Ээлжит бус чуулганаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөс гадна дараах асуудлуудыг хэлэлцэнэ гэж байгаа.

- ♦ “Оюутолгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий”
- ♦ Улсын Их Хурлын Ажлын хэсгийн ажлын тайлан, үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлаас гаргах шийдвэрийн төслийн тухай,
- ♦ Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар дүгнэлт, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”



САЙХАН НААДААРАЙ

ТУЛГАР ТӨРИЙН 2228 ЖИЛ, ИХ МОНГОЛ УЛСЫН 813 ЖИЛ
АРДЫН ХУВЬСГАЛЫН 98 ЖИЛИЙН ОЙН БАЯР НААДМЫН МЭНД ДЭВШҮҮЛЬЕ !

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

 editor1@jargaldefacto.com

 +976 94109342

 www.defacto.mn

www.jargaldefacto.com